



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Ажил эрчимжүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, төрийн байгууллагын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Албаны хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж буй нийгмийн даатгалын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх /2 сарын аян/-ыг 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

2.Аяны хугацаанд төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг дэд дарга, /дэд хурандаа, Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт даалгасугай.

3.Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг дүүргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

4.Дүнг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр танилцуулахыг дэд дарга /дэд хурандаа, Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт үүрэг болгосугай.

5.Аяны хугацаанд үр дүн гаргаж ажиллаагүй албан хаагчид хариуцлага тооцохыг анхааруулсугай.

ДАРГА, ХУРАНДАА



Э.БАТБАЯР

812335133525
2014 tushaal

БАТЛАВ:
ДАРГА, ХУРАНДАА



Э.БАТБАЯР

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН НЭХЭМЖЛЭЛТЭЙ ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧГИЙН
БОДИТ БИЕЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ 2 САРЫН АЯНЫ ХУГАЦААНД ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2014.10.10

Улаанбаатар хот

1. Аяны зорилго.

Нийгмийн даатгалын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх зорилгоор гаргасан албаны даргын 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/134 дугаар тушаалыг хэрэгжүүлэхэд аяны зорилго оршино.

2. Аяны хугацаанд хийгдэх ажил, хугацаа

1. Аяныг 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд төлөвлөгөө гарган ажиллана.

2. Аяны хугацаанд нийгмийн даатгалын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг нэмэгдүүлж, өргөдөл гомдол санал хүсэлтийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж дахин гаргуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3. Аяны хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, болон дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллаж мэдээ тайланг албаны хэмжээнд нэгтгэж, 14 хоног тутам тулгалт хийн үлдэгдлийг баталгаажуулж байна.

4. Аяны хугацаанд хийсэн ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр албаны даргад илтгэх хуудсаар танилцуулж, үр дүн гаргаж ажиллаагүй албан хаагчдад хариуцлага тооцуулах саналыг албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

5. Тушаалын хэрэгжилт ажлын тайланг 2014 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор удирдах дээд байгууллагад хүргүүлсэн байна.